

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хяналт шалгалт, үнэлгээний газар



ᠮᠤᠩᠭᠡᠯᠤᠯᠤᠰᠤ
ᠶᠡᠬᠡᠬᠤᠷᠭᠠᠯᠤᠯᠤᠰᠤ
ᠲᠠᠮᠭᠢᠨᠭᠠᠵᠢᠷᠢᠨ
ᠬᠢᠶ᠋ᠠᠨᠯᠠᠲᠤᠰᠢᠯᠠᠭᠠᠯᠲᠤ
ᠦᠨᠡᠯᠭᠡᠨᠢᠶᠢᠭᠠᠵᠢᠷ

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН САРЫН МЭДЭЭ

(2021 оны 6 дугаар сар)

Улаанбаатар хот
2021 он

АГУУЛГА

НЭГ. ТҮР ХОРОО

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

- 2.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ
- 2.2. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ
- 2.3. ДЭД ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ
- 2.4. ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ДУУСГАВАР БОЛСОН АЖЛЫН ХЭСЭГ

ГУРАВ. УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГЫН ХАРИУ, АСУУЛГА, АСУУЛТ

- 3.1. АСУУЛГЫН ХАРИУ
- 3.2. АСУУЛГА
- 3.3. АСУУЛТ

ДӨРӨВ. ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ, ИЛТГЭЛ

ТАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

- 5.1. ХЯНАЛТАД БАЙГАА ХУУЛЬ, ТОГТООЛ
- 5.2. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ



ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЖЛЫН САРЫН МЭДЭЭ

НЭГ. ТҮР ХОРОО

Улсын Их Хурлын тогтоолоор тодорхой асуудлыг шалган судалж, санал дүгнэлт гаргах үүрэг бүхий 2 түр хороо байгуулагдан ажиллаж байна.

Хүснэгт 2. Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан түр хороо

Д/д	Түр хороо байгуулсан тогтоол	Түр хорооны бүрэлдэхүүн
1.	2020.10.29 №31 Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай УИХ-ын тогтоол /КОВИД-19/	Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр Түр хорооны гишүүд: УИХ-ын гишүүн Х.Болорчулуун, Ж.Мөнхбат, Н.Учрал, М.Оюунчимэг, Б.Жавхлан, Б.Чойжилсүрэн, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, Б.Бейсен, С.Ганбаатар, Т.Доржханд, Б.Бат-Эрдэнэ, Л.Энх-Амгалан, Н.Алтанхуяг ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох, Х.Хэрлэн
2.	2021.3.26 №30 Түр хороог байгуулах тухай УИХ-ын тогтоол /Оюу толгой/	Түр хорооны дарга: УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн Түр хорооны гишүүд: УИХ-ын гишүүн Ш.Адьяа, Н.Алтанхуяг, П.Анужин, Ё.Баатарбилэг, Б.Бат-Эрдэнэ, Ж.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, С.Бямбацогт, Ж.Ганбаатар, С.Ганбаатар, Г.Ганболд, Н.Ганибал, Х.Ганхуяг, Г.Дандинням, Б.Дэлгэрсайхан, Б.Жаргалмаа, Ж.Мөнхбат, Ц.Сандаг-Очир, Ж.Сүхбаатар, Г.Тэмүүлэн, Ч.Ундрам, С.Чинзориг, Б.Энхбаяр ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.4-т тодорхой асуудлыг шалган судалж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороо байгуулах




1. УИХ-ын 2020 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, хяналт тавих, шаардлагатай бол УИХ-ын холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий түр хороо байгуулагдсан.

Түр хорооны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн биелэлт, цар тахлын үед Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээлэл болон Түр хорооны 7 дугаар хуралдаанаас өгсөн үүргийн биелэлтийн талаар Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдалд Эрүүл мэндийн байгууллагуудаас хэрэгжүүлж буй арга хэмжээ, халдварын дэгдэлтийг бууруулах арга зам, вакцинжуулалтын үр нөлөө, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж болон бусад улс орнуудын туршлагын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд нар тус тус мэдээлэл хийв.

Тус хуралдаанаас Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд холбогдох Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эмчилгээ, эмнэл зүй, тархвар судлалын асуудлаар Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд мэдээлэл хийх үүргийг Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яаманд тус тус өгсөн. Түр хорооноос Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яамны мэдээллийг Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх чиглэлийг УИХ-16/5316 тоот албан бичгээр өгөв.

2. Улсын Их Хурлын 2021 оны 30 дугаар тогтоолоор байгуулагдсан “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай бол санал боловсруулж, дүнг нэгдсэн хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Түр хороо байгуулагдсан.

Түр хороо 6 дугаар сарын 29-ний өдөр цахимаар хуралдаж, Засгийн газрын ажлын хэсгийн явцын талаарх мэдээллийг сонсож, Түр хорооны даргын өгсөн чиглэлийн дагуу цаашид хөрөнгө оруулалтын гэрээг сайжруулах, шүүхэд гаргасан сөрөг нэхэмжлэлийн асуудлыг эрчимжүүлэх, гэрээг зөрчсөн асуудлыг судалж танилцуулах, Оюу толгойн болон Эрдэнэт Төрийн өмчит үйлдвэрийн газрын зэсийн баяжмалын боруулалтын харьцуулсан судалгаа хийхийг хуралдааны тэмдэглэлээр Засгийн газарт чиглэл өгөхөөр болов.




2021 оны 6 дугаар сарын байдлаар хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий нийт **13 ажлын хэсэгт давхардсан тоогоор Улсын Их Хурлын 92 гишүүн** ажиллахад Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газар мэргэжил, арга зүй, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

Нийт 13 ажлын хэсгээс:

- УИХ-ын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 5,
- Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг 7,
- Дэд хорооны тогтоолоор байгуулагдсан 1 ажлын хэсэг үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

График 1. 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр ажиллаж буй ажлын хэсгийн статистик мэдээ /байгуулагдсан хугацаагаар/

- 2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (5)
- 2020 оны намрын чуулганы завсарлагааны хугацаанд байгуулагдсан (2)
- 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан (6)



Хүснэгт 1. 2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд хяналт шалгалтын чиглэлээр ажиллаж буй ажлын хэсгийн статистик мэдээ /тогтоол, захирамж, шийдвэрийн төрлөөр/

Хугацаа	УИХ-ын даргын захирамж	Байнгын хорооны тогтоол	Дэд хорооны тогтоол
2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	-	5	1
2020 оны намрын чуулганы завсарлагааны хугацаанд байгуулагдсан	2	-	-
2021 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд байгуулагдсан	3	2	-
Нийт - 13	5	7	1

2.1. УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГЫН ЗАХИРАМЖААР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ



2021 оны 6 дугаар сарын байдлаар Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан 5 ажлын хэсэг ажиллаж байна. Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанаас онцолбол:

1. Улсын Их Хурлын даргын 2021 оны 16 дугаар захирамжаар байгуулагдсан Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын дэд хэсгийн гишүүд вакцины нийлүүлэлт, нөөц, үлдэгдэл, вакцин хийлгэсэн хүмүүсийн хэдэн хувь нь халдвар авч байгаа талаар болон 12-15 насны хүүхдүүдэд вакцин хийх газруудын байршил, вакцинжуулалтын талаарх мэдээллийг Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс тогтмол авч, ажлын хэсгийн гишүүдийг тухай бүр мэдээллээр ханган ажиллаж байна.

2. Улсын Их Хурлын даргын 2021 оны 18 дугаар захирамжаар байгуулагдсан Концессын тухай хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах, санал, дүгнэлт гарган шийдвэрийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн ахлагчаас өгсөн чиглэлийн дагуу 2014 онд байгуулсан Концессын гэрээ, 2019 онд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ажлын хэсгийн дүгнэлт, Дархан төмөрлөг ХК-аас ирүүлсэн тайлбарт зэрэгцүүлсэн байдлаар санал, дүгнэлт боловсруулж Ажлын хэсгийн ахлагчид хүргүүлээд байна.

Хүснэгт 3. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан захирамж	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
1.	2021.3.02 №16 захирамж Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хүрээнд Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Б.Жаргалмаа, С.Одонтуяа, М.Оюунчимэг, Ж.Сүхбаатар ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Х.Хэрлэн
2.	2021.3.11 №18 захирамж Концессын тухай хууль тогтоомж, гэрээний хэрэгжилтийг Дарханы төмөрлөгийн үйлдвэрт хэрхэн хэрэгжүүлж байгааг шалгах, санал, дүгнэлт гарган, шийдвэрийн төсөл боловсруулж Улсын Их Хуралд танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Дамдинням Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, Х.Болорчулуун, Х.Ганхуяг, Д.Өнөрболор, Г.Тэмүүлэн, Ч.Ундрэм О.Цогтгэрэл ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Д.Гэрэлт-Од
3.	2021.3.18 №21 захирамж Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор газар эзэмших, ашиглахтай холбоотой газрын харилцааг зохицуулсан хууль тогтоомж болон Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Мөнхбат Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ш.Адъяаа, П.Анужин, Б.Бат-Эрдэнэ, Б.Жаргалмаа ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт К.Пүрэвсүрэн
4.	2021.4.08 №28 захирамж Хууль хяналтын байгууллагад хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйд болон хэвлэл мэдээллийн орчинд тархсан гэмт хэргийн шинжтэй мэдээллүүд нь улс орны дотоод аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эсэхийг судлан санал, дүгнэлт гаргах, хууль тогтоомжийн төсөл боловсруулж, танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Энх-Амгалан Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Б.Баярсайхан, Г.Дамдинням, Ц.Сандаг-Очир, Ч.Ундрэм ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг
5.	2021.5.10 №33 захирамж Улс төрийн нөхцөл байдалтай холбогдуулан Улсын Их Хурлаас баталсан холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг шалгах санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил Ажлын хэсгийн дэд ахлагч: УИХ-ын гишүүн Н.Ганибал Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ж.Батсуурь, Ц.Мөнхцэцэг, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт К.Пүрэвсүрэн

2.2. БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.7-д Байнгын, дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд хяналт шалгалт хийх

2021 оны 6 дугаар сарын байдлаар Байнгын хорооны тогтоолоор нийт 7 ажлын хэсэг ажиллаж байгаагаас: БСШУСБХ-ны эрх асуудлын хүрээнд 1, ТБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд 3, ХЗБХ-ны эрхлэх асуудлын хүрээнд 3 ажлын хэсэг тус тус ажиллаж байна. Ажлын хэсгүүдийн үйл ажиллагаанаас онцолбол:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 7 дугаар сарын 06-ны өдөр баталсан Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилт, салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн талаар шалгаж санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд Монголын үндэсний олимпын хороо, Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төв, Спортын шинжлэх ухаан, биеийн тамирын боловсролын холбоо, Монголын үндэсний олимпын академитай хамтран 6 дугаар сарын 02-ны өдөр “Биеийн тамир спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, биеийн тамир, спортын хөгжлийн тулгамдсан асуудлуудаар санал, дүгнэлт гаргах, тогтоолын төсөл боловсруулах” асуудлаар их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургуулийн багш, эрдэмтэн, судлаачид, спортын холбоодын удирдлага, дасгалжуулагч, аймаг, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагуудын удирдлага, албан хаагчид болон бусад салбарын эрдэмтэн, судлаач зэрэг нийт 78 хүнийг хамруулсан цахим уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулав.

2. Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 7 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд Хууль зүйн байнгын хорооны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн тайланг хэлэлцүүлж, Байнгын хорооны 13 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газарт “Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах тухай” үүргийг өгсөн.

Хүснэгт 4. Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор байгуулагдсан ажлын хэсэг

Д/д	Ажлын хэсэг байгуулсан тогтоол	Ажлын хэсгийн бүрэлдэхүүн
Төсвийн байнгын хороо		
1	2020.11.04 №05 тогтоол Монгол Улсын сүүлийн 15 жилийн төсвийн бодлого, төсвийн тэнцэлд дүн шинжилгээ хийж, цаашид баримтлах төсвийн бодлогын талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Х.Булгантуяа Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, Г.Амартүвшин, Х.Баделхан, Ж.Батсуурь, Г.Тэмүүлэн, Б.Чойжилсүрэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ТХШХ-ийн ажилтнууд
2	2020.12.30 №07 тогтоол Төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1.3, 8.3.15 дахь дэд заалтын биелэлтэд хяналт тавих зорилгоор төсвийн ерөнхийлөн захирагч болон хууль тогтоомжийн дагуу төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээдэг төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн 2019-2020 оны үйл ажиллагааг хамруулан шалгаж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн С.Ганбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: ТХШХ-ийн ажилтнууд
3	2021.01.20 №01 тогтоол Монгол Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолын (Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай) хэрэгжилтийг хангуулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Г.Тэмүүлэн Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Анандбазар, Х.Булгантуяа, С.Ганбаатар, Л.Мөнхбаатар, М.Оюунчимэг, Б.Пүрэвдорж ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх М.Солонго, референт Д.Гэрэлт-Од

Хууль зүйн байнгын хороо		
4	2020.12.24 №09 тогтоол Монгол Улс олон талт олон улсын гэрээнд нэгдэн орсноор хүлээсэн үүргийн хэрэгжилтийн тайланг холбогдох олон улсын байгууллагад хүргүүлэх, тайлантай холбогдуулан олон улсын байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлж байгаа ажлын явц байдалтай танилцах, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн С.Амарсайхан, С.Бямбацогт, Б.Пүрэвдорж, Ц.Сэргэлэн ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Б.Нандингэрэл
5	2021.3.15 №07 тогтоол Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хууль / шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг
6	2021.3.15 №08 тогтоол Гүйцэтгэх ажлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах явцад хүний үндсэн эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих, хариуцлага тооцох чиглэлээр хэрхэн ажиллаж байгаад үнэлгээ хийж, санал, дүгнэлт гаргах, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох тухай хууль тогтоомжийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Б.Энхбаяр Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг, С.Бямбацогт, Д.Ганбат, Б.Энх-Амгалан ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Ахлах зөвлөх Ч.Онончимэг
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо		
7	2021.4.27 №02 тогтоол “Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 7 дугаар сарын 06-ны өдөр баталсан Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж, санал, дүгнэлт гаргах шийдвэрийн төсөл боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсэг.	Ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Ц.Мөнхцэцэг Ажлын хэсгийн гишүүд: УИХ-ын гишүүн Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Б.Жаргалмаа, Ч.Ундрэм, Ж.Чинбүрэн, Т.Энхтүвшин ХШҮГ-аас мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж буй ажилтан: Зөвлөх С.Эрдэнэчимэг, референт Ц.Рэнцэнтогтох

2.3. ДЭД ХОРООНЫ ТОГТООЛООР БАЙГУУЛАГДСАН АЖЛЫН ХЭСЭГ

Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны 2020 оны 1 дүгээр тогтоолоор байгуулагдсан Уурын болон усан халаалтын зуухтай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд 6 дугаар сарын 27-ны өдөр Агаарын бохирдлыг бууруулах асуудлыг дэд хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч Б.Саранчимэг Баянзүрх дүүргийн 421 дүгээр нээлттэй хорих ангийн нам даралтын зуухыг төвлөрсөн дулааны шугамд холбох ажилтай газар дээр нь очиж танилцав. Мөн Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хороонд “Үндэсний технологийн уур үйлдвэрлэгчдийн холбоо” төрийн бус байгууллагаас ирүүлсэн хүсэлттэй холбогдуулан уулзалт зохион байгуулахаар тогтов.

2.4. ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ДУУСГАВАР БОЛСОН АЖЛЫН ХЭСЭГ

Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2020 оны 02 дугаар тогтоолоор байгуулагдсан Эрүүл мэндийн салбар дахь цахим шилжилттэй холбоотой хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилттэй танилцах, цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг Инновац, цахим бодлогын байнгын хорооны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар ажлын хэсгийн тайланг хэлэлцүүлж, Байнгын хорооны 01 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газарт үүрэг, чиглэл өгөх тухай тогтоолыг батлуулж, тогтоолын хэрэгжилтийг 2021 оны намрын ээлжит чуулганы хугацаанд танилцуулах үүргийг өгснөөр ажлын хэсгийн үйл ажиллагаа дуусгавар болсон.



2021 оны 6 дугаар сард Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга нарт тавьсан 2 асуулгын хариу ирж, 1 асуулга, 2 асуулт тавьсан байна.

3.1. АСУУЛГЫН ХАРИУ

6 дугаар сарын байдлаар өмнөх сард Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад хандан тавьсан 2 асуулгын хариуг ирүүлсэн байна.

1. Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгээс Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайд З.Мэндсайханд хандан “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний экспортын боломжийг нээх болон “Монгол мал-II” арга хэмжээний хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаар” тавьсан асуулын хариуг 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдөр 01/1744 дүгээр албан бичгээр;



2. Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибалаас Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн өнөөгийн байдал, хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа арга хэмжээний талаар” тавьсан асуулгын хариуг 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ХЭГ/1726 дугаар албан бичгээр. /<https://qr.go.page.link/s3FCT/>

3.2. АСУУЛГА

6 дугаар сард Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад 1 асуулга тавьсан байна.



1. Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандан “Монгол Улсын гадаад өрийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид баримтлах бодлогын талаар” 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 22 дугаар асуулга. /<http://parliament.mn/n/dhzyn/>

3.3. АСУУЛТ

2021 оны 6 дугаар сард Улсын Их Хурлын гишүүдээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын даргад нийт 2 асуулт тавьсан байна.



1. Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямаас Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт хандан “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын чанар болон гүйцэтгэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хэрхэн хангаж ажиллаж байгаа талаар” 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 23 дугаар асуулт; /<http://parliament.mn/n/fazyn/>



2. Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямаас Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтарт хандан “Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын ажлын гүйцэтгэгчтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар” 2021 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 24 дүгээр асуулт; /<http://parliament.mn/n/fhzyn/>

Улсын Их Хурлаар хэлэлцэхээр хуульд тусгайлан заасан мэдээлэл, тайлан, илтгэл, танилцуулгыг эрх бүхий байгууллага хуульд заасан хугацаанд ирүүлэх үүрэгтэй бөгөөд холбогдох Байнгын хороо харьяаллын дагуу хэлэлцдэг. 2021 оны 6 дугаар сард Байнгын хорооны хуралдаанаар нийт 5 тайлан, мэдээлэл, илтгэл сонссон байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы
хуралдааны дэгийн тухай хуулийн
113, 114 дүгээр зүйл

1. Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар :

- “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны 2020 оны 01 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаарх Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл.

2. Хууль зүйн байнгын хорооны 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар:

- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэл

3. Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар:

- Малчдаас ирүүлсэн өргөдөл, хүсэлттэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл;
- Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны Мах бэлтгэл, махны үйлдвэрлэл болон махны экспортын үйл ажиллагааны тухай 2020 оны 10 дугаар тогтоолын биелэлтийн талаарх Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл

2. Нийгмийн бодлогын байнгын хорооны 2021 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар :

- Коронавируст халдвар /КОВИД-19/-ын эмчилгээ, эмнэл зүй, тархвар судлалын талаар Эрүүл мэндийн сайд болон Улсын онцгой комиссын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлийн мэдээлэл.

ТАВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

5.1. ХЯНАЛТАД БАЙГАА ХУУЛЬ, ТОГТООЛ

Улсын Их Хурлын Хяналт шалгалт, үнэлгээний газрын мэдээллийн санд 2021 оны 6 дугаар сарын байдлаар Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрээр Засгийн газар болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагад үүрэг, чиглэл өгсөн 121 хуулийн 436 хэсэг, заалт, Улсын Их Хурлын 86 тогтоолын 275 заалт, Байнгын, дэд хорооны 88 тогтоолын 484 заалтыг хяналтад авч, шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Үүнээс 6 дугаар сард шинээр хяналтад авсан дараах хууль, тогтоолын зүйл, хэсэг, заалтыг хяналтад авсан.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.4-д хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах


Хууль, тогтоолын нэр, огноо	6 дугаар сард шинээр хяналтад авсан хууль, тогтоолын зүйл, хэсэг, заалт
Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хууль 2021.04.23	2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан барааны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.
Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль 2021.04.23	2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан барааны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.
Хоршооны тухай /шинэчилсэн найруулга/ 2021.05.06	<p>23.2.Хоршооны нягтлан бодох бүртгэлийн журам, зааврыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.</p> <p>42.1.Хоршооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх:</p> <p>42.1.7.улсын шилдэг хоршоог шалгаруулах, шагнах журмыг батлах.</p> <p>42.1.9.Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмыг батлах, уг сангийн зарцуулалтад хяналт тавих, нэгдсэн бодлого, удирдлагаар хангах.</p> <p>43.2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хоршооны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>43.2.1.хоршоог дэмжих, хоршооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>46.1.Хоршооллын байгууллагуудын хөгжлийн чиг хандлага, бодлогыг тодорхойлж, хоршоодыг тогтвортой хөгжих таатай орчныг бүрдүүлэх зорилгоор хоршоодын холбоод нэгдэж, Хоршооллын нэгдсэн холбоог байгуулж болно.</p>
Хууль зүйн байнгын хорооны тогтоол МУ-ын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангах тухай 2021.06.15. №13	<p>1/ Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 03 дугаар дүгнэлттэй холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны гишүүний сонгон шалгаруулалтыг Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасан 120 хоногийн дотор зохион байгуулах боломжгүй болсон тул Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ыг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд нэн яаралтай өргөн мэдүүлэх;</p> <p>2/ Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д заасны дагуу Нийт шүүгчийн чуулганыг зохион байгуулах үед шаардагдах төсөв, санхүүгийн асуудлыг Засгийн газрын нөөц сангаас гаргах асуудлыг судлан шийдвэрлэх;</p> <p>3/ Шүүн таслах ажиллагааг бие даасан хараат бусаар явуулах, иргэдэд шүүхийн үйлчилгээг хүртээмжтэй, аюулгүй хүргэх нөхцөлийг хангах, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны үйл ажиллагааг хэвийн явуулах зориулалтын шаардлага хангасан барилга байгууламжийнх нь асуудлыг шийдвэрлэх, төрийн өмчийн зарим барилга байгууламжийг шүүхийн байгууллагад шилжүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх.</p>



5.2. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын талаар

1.2021 оны 6 дугаар сарын байдлаар нийт 4 хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үр дагаврын үнэлгээ хийж байна. Үүнд:



- Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Номын сангийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ;
- Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ зэрэг болно.

2.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэлд үнэлгээ хийж, чуулганы нэгдсэн хуралдаанаар сонссон. Монгол Улсын Засгийн газар, Хүний эрхийн үндэсний комисст чиглэл өгөх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж байна.

3.Улсын Их Хурлын 2020 оны “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 45 дугаар тогтоол, 2021 оны “Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар тогтоолын хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэсэн.

